



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 06 өдөр

Дугаар А/541

Есөнбулаг сум

Хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Боловсролын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын "Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай" 2025 оны 06 дугаар тогтоол, 2025 оны Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 25 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2025 оны анги нийтийн сорилгын бага ангийн шалгалтын материалыг хэвлэн олшруулахад шаардагдах 1,500,000 (нэг сая таван зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргаж, Боловсролын газар (Д.Энхцэцэг)-т шилжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

2.Захирамжийн хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн зарцуулалтыг тайлагнан ажиллахыг Боловсролын газрын дарга (Д. Энхцэцэг)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Ж.Амгаланбаатар), Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ф.ЧИНБАТ

